**Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

| | |
|---|---|
| Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/ | 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр |
| Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар | Премиум Нэксус ХК<br>УБ-ийн дугаар 9007001006, РД 6155804<br>ҮЦ-ны код CUMN<br>Утас 976-7733-0101 |
| Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр | Монголын Хөрөнгийн Бирж ХК |
| Бизнесийн үйл ажиллагааны салбар | Хүнсний дэлгүүр;<br>Хүнсний үйлдвэрлэл;<br>Худалдааны зуучлал;<br>Франчайзын гэрээний үндсэн дээр бизнесийн үйл ажиллагаа явуулах;<br>Гадаад худалдаа;<br>Менежментийн зөвлөх үйлчилгээ. |
| Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо | Кэй Пи Эм Жи Аудит ХХК |
| Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг | 1,114,252,034 ширхэг энгийн хувьцаа |
| Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр | Бэлтгэсэн: Санхүүгийн газрын захирал, бизнес Контроллер Д.Будханд<br>Хянасан: Гүйцэтгэх захирлын орлогч Г.Чинзориг |

| | | |
|---|---|---|
| 1. | Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/ | |
| | Санхүүгийн байдлын үзүүлэлт | Нийт хөрөнгө : 313,931,452 мянган төгрөг<br>Нийт өр төлбөр : 211,142,643 мянган төгрөг<br>Эздийн өмч : 102,788,809 мянган төгрөг |
| | Орлогын тайлан | Борлуулалтын орлого : 598,378,660 мянган төгрөг<br>Нийт ашиг : 80,105,874 мянган төгрөг<br>Татварын дараах цэвэр ашиг : 47,402,494 мянган төгрөг |
| | Өмчийн өөрчлөлтийн тайлан | Хувьцаат капитал: 111,425,203 мянган төгрөг<br>Нэмж төлөгдсөн капитал: 45,757,916 мянган төгрөг<br>Эздийн өмчийн бусад хэсэг: 318,731 мянган төгрөг<br>Хуримтлагдсан ашиг/(алдагдал): (63,586,419) мянган төгрөг |
| | Мөнгөн гүйлгээний тайлан | Үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал : 54,592,177 мянган төгрөг<br>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн урсгал : (33,531,769) мянган төгрөг<br>Санхүүжилтийн цэвэр мөнгөн урсгал : (13,873,498) мянган төгрөг |
| 1.1. | Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт | |

| | | |
|---|---|---|
| | Аудитын дүгнэлтийг хавсаргав. | |
| 1.2. | Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/ | |
| | Аудиторын тодорхойлох захидлыг хавсаргав. | |
| 2. | Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл | |
| 2.1. | Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/ | Цэвэр ашгийн хувь 7.9%<br>Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 0.19<br>Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж (ROE) 0.37<br>Нийт хөрөнгийн эргэц (ROTA) 0.26<br>Нэгж хувьцааны өгөөж (EPS) 42.54<br>Үнэ ашгийн харьцаа (P/E ratio) 4.90 |
| 2.2. | Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт | Эргэлтийн харьцаа 0.67<br>Түргэн хөрвөх чадварын харьцаа 0.18 |
| 2.3. | Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл | 2024 онд Премиум Нэксус ХК нь ашигтай ажиллаж эхэлсэн анхны жил байлаа. Монголын ТОП 100 аж ахуйн нэгжийн жагсаалтад 8-р байранд эрэмбэлэгдэв.<br>2024 онд нийт салбарын тоог 71-ээр нэмэгдүүлж 445 салбартай болоод байна. Үүнээс 12 аймагт 49 салбар дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна. Ингэснээр орон нутагт:<br>- Хүнсний аюулгүй байдлыг хангасан ОУ-ын стандартад нийцсэн үйлчилгээг үзүүлж,<br>- Аялал жуулчлал, үйлчилгээний дэд бүтцийг сайжруулж<br>- Шинээр ажлын байр бий болгож<br>- Орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллаж байна.<br>Мөн үйл ажиллагаандаа тогтвортой хөгжлийн зорилтуудад хувь нэмрээ оруулан ажиллаж байна.<br><br>CU-ийн бизнесээс гадна Премиум Нэксус ХК нь “CU төвтэй бизнесийн экосистем”-ийг бүрдүүлэн бизнесийн цар хүрээгээ өргөтгөн ажиллаж байгаа нь үр дүнгээ өгч байна.<br><br>Дэлгэрэнгүй мэдээллийг үйл ажиллагааны тайлангаас үзнэ үү. |
| 2.4. | Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/ | Байхгүй |
| 2.5. | Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл; | Тайлант хугацаанд 63,371,715 мянган төгрөгийн зээл авч, 66,526,553 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийсэн. |
| 3. | Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/ | |

- Их хэмжээний хэлцэл:  Их хэмжээний хэлцэл байхгүй.
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл : Компани нь тайлант хугацаанд 1 сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн бөгөөд энэ нь өөрийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор нэгдмэл сонирхолтой этгээд болох Премиум Конкрит ХХК-иас 17.1 хувийн хүүтэй 8-н тэрбум төгрөгийн богино хугацаат зээл авсан хэлцэл байв. Тус зээлийг гэрээнд заасан хугацаанд нь төлж барагдуулсан.

4. Цалин урамшууллын мэдээлэл

- БОНЗ тайландаа тусган дахин хүргүүлнэ.

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

1. 2024 оны 04-р сарын 25-ны өдөр хуралдуулсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан, тайлангийн талаарх дүгнэлтийг баталж, Компанийн 2023 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэр, түүний шалтгаантай танилцсан.
2. ТУЗ-ийн гишүүн З.Уянга-г 2024 оны 11-р сарын 07-ны өдрөөр үүрэгт ажлаас чөлөөлж, түүний оронд Ч.Мөнхчимэгийг ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн Байгаль орчин, нийгэм, засаглалын хорооны гишүүнээр түр томилсон.
3. Компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай, хүнсний бөөний болон жижиглэн худалдаа, хүнсний агуулахын болон тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах Премиум Коммерс ХХК, тээвэр ложистикийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах Премиум Нэксус Ложистик ХХК-иудыг үүсгэн байгуулсан.

6. Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл




7. Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/

| Хувьцаа эзэмшигчид | 2024 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар | |
|---|---|---|
| | Эзэмшлийн хувьцааны тоо | Эзэмшлийн хувь |
| А.Ганхуяг | 300,848,138 | 27.00% |
| А.Ганболд | 207,204,006 | 18.60% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Премиум Групп ХХК | 191,266,240 | 17.17% |
| | | БиЖиЭф Ритэйл Ко., Лтд. | 92,600,479 | 8.31% |
| | | Ц.Баяржаргал | 88,164,258 | 7.91% |
| | | Олон нийт | 234,168,913 | 21.02% |
| | | **Нийт** | **1,114,252,034** | **100.00%** |
| 8. | Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл | | | |
| | Тайлант хугацаанд олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлээгүй. | | | |
| 9. | Ногдол ашгийн мэдээлэл | | | |
| | ТУЗ-өөс 2025 оны 02-р сарын 10-ны өдрийн 2 тоот тогтоолоор 2024 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. | | | |
| 10. | Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл | | | |
| | Дэлгэрэнгүй мэдээллийг Премиум Нэксус ХК-ийн үйл ажиллагааны тайлангаас үзнэ үү. | | | |
| Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо: | | | | |

| | |
|---|---|
| Овог, нэр: Г.Чинзориг<br><br>Албан тушаал: “Премиум Нэксус” ХК-ийн гүйцэтгэх захирлын<br>орлогч<br><br>Гарын үсэг: ……………………………………… | (Тамга/тэмдэг) |
| Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: | |
| Овог, нэр: Д.Бүдханд<br><br>Албан тушаал: Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллер<br><br>Гарын үсэг: ……………………………………… | |